



УЛААНБААТАР  
хотын Ардын Депутатуудын  
хурлын Гүйцэтгэх Захиргааны  
ТОГТООЛ

1969 оны 4 сарын 24 ны өдөр

Дугаар 163

Улаанбаатар хот

ТЗ-ийн 1990 тоо 140

ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ.

Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргаанаас  
ТОГТООХ нь:

Улаанбаатар хотын барилга засварын трестийн дүрмийг  
баталсугай.

дүрмийг хавсаргав.

УЛААНБААТАР ХОТЫН АДХ ЫН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРГААНЫ I-Р ОРЛОГЧ ДАРГА  
УЛААНБААТАР ХОТЫН АДХ ЫН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Д.ШИРНИН

Д.ДАМДИНСҮРЭН

Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх  
Захиргааны гишүүдийн 1969 оны 4-р  
сарын 24-ны өдрийн .....-р тогтоолоор  
батлав.

УЛААНБААТАР ХОТЫН БАРИЛГА ЗАСВАРЫН  
ТРЕСТИЙН ДҮРЭМ.

Нэг. Ерөнхий анги.

1. Хотын барилга засварын трестийн үндсэн зорилт нь хотын албан үйлдвэр, соёл үйлчилгээний байгууллагуудын үндсэн фондын гол хэсэг болсон орон байрыг чанар үзэмж сайтай засварлан үйлчлэх явдал мөн.

2. Хотын барилга засварын трест нь Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны шууд удирдлаганд ажиллаж, нам төрийн дээд байгууллагын баталсан хууль дүрэм, тогтоол, заавруудыг мөрдлөг болгон ажиллана.

3. Хотын барилга засварын трест нь аж ахуйн тооцооны үндсэн дээр биеэ даасан тайлан бэлэнстэй хуулийн этгээд мөн.

4. Хотын барилга засварын трест нь барилга засвар, цахилгаан сантехник, Туслах үйлдвэр, Авто граж зэрэг 4 үндсэн ангиудаас бүрдэх бөгөөд уул трестийг байгуулах татан буулгах, асуудлыг хотын АДХ-ын гүйцэтгэх Захиргааны оруулсанаар Сайд нарын Зөвлөлийн шийдвэрээр гүйцэтгэнэ.

5. Хотын барилга засварын трест нь батлагдсан орон тоо ба барилга санхүүгийн төлөвлөгөөний үндсэн дээр ажиллах бөгөөд, Хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны захирамжаар томилогдсон дарга удирдана.

6. Хотын барилга засварын трест нь батлагдсан тэмдэг, бичгийн нүүртэй байна.

Хоёр. ХОТЫН БАРИЛГА ЗАСВАРЫН ТРЕСТИЙН  
ЭРХ.

7. Хотын барилга засварын трест нь өөрийн мэдлийн ажилтан ажилчдын ажил үүргийг дотоод журмын дагуу хувиарлан тогтоохын хамт ажилд авах, чөлөөлөх эрхтэй.

8. Хотын барилга засварын трест нь бусад байгууллагуудтай аж ахуйн ба барилга засварын ажлын I жилийн гэрээ хийх, итгэмжлэх олгох, шүүх, арбитрын байгууллагаар нэхэмжлэх ба хариуцах эрхтэй байна.

9. Хотын барилга засварын трестийн дарга нь олгогдсон эрх хэмжээний дотор тушаал гаргана.

10. Улсын ба хөдөлмөрийн сахилга алдсан ажилтан ажилчдыг хөдөлмөрийн хуумьд заасан сахилга батын арга хэмжээ авна.

11. Хөдөлмөрийн өндөр бүтээл гаргасан, шинийг санаачилсан, социалист уралдаанд шалгарсан хүмүүсийг шагнаж урамжуулах.



Гурав. Барилга засварын трестийн  
үүрэг.

12. Хотын барилга засварын трест нь Улаанбаатар хотын эмнэлэг, сургууль, цэцэрлэг, ясли болон бусад албан ба үйлдвэрийн газруудын барилга, сантехник, цахилгаан, байгууламжуудын их, дунд, урсгал засварын ажлыг өгөгдсөн төлөвлөгөө, гэрээний дагуу хийж гүйцэтгээд захиалагчид зураг төсвийн ёсоор хүлээлгэж өгнө.

13. Аппаратын хөдөлмөр зохион байгуулалт, ажилтан, ажилчдын сахилга бат, хариуцлагыг байнга дээшлүүлэх, төрийн хууль дүрэм, дээд газрын тогтоол, шийдвэрийн биедэлтэнд гүйцэтгэлийн шалгалт хийж байх.

14. Барилга засварын ажилд орчин үеийн машин механизм багаж хэрэглэлийг бүрэн ашиглаж, гар ажиллагааг дээд хэмжээгээр механикжуулан, оновчтой санал тэргүүн туршлагауудыг ажилдаа нэвтрүүлж, ажилчдын дунд социалист хөдөлмөрийн хөдөлгөөн, социалист уралдааныг өрнүүлэх замаар засвар үйлчилгээний ажлыг хөнгөн шуурхай болгох.

15. Барилга засварын ажлыг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулж, мэрэгжилтэй боловсон хүчнийг бэлтгэх, ажилчдын мэрэгжлийг дээшлүүлэх ажлыг байнга зохиож ажиллана.

16. Ажлын салбар бүхэнд гүйцэтгэлийн хяналт шалгалтыг тогтмолжуулж, тооцоо тоо бүртгэлийг байнга сайжруулан, ажилчдын хөдөлмөр хамгаалалын нөхцөлүүдийг хангаж байх.

17. Барилга засварын трест нь барилга санхүүгийн  
төлөвлөгөөгөөр батлагдсан хөрөнгө, үйлдвэрийн мэдлийн  
фондотой байна.

-----"-----

НИЙЛСЭН \_\_\_\_\_

5%-ц-А.813487.